



РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А117

Улаанбаатар хот

Журам батлах тухай

"Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.3.10 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, "Сүлжээний дэд бүтэц ашиглах техникийн нөхцөл олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Сүлжээний дэд бүтэц ашигласан ажлын гүйцэтгэлийн шалгасан техникийн актын маягт"-ыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг инженер техникийн ажилтнуудад танилцуулж, мөрдүүлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Техникийн хэлтэс /Б.Цэрэндорж/-д үүрэг болгосугай.


3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс /Л.Ууганцэцэг/-т даалгасугай.

ЗАХИРАЛ



С.ЦАГААНХҮҮ

000003'



Радио телевизийн үндэсний сүлжээ"
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын
2021 оны 1117 тушаалын нэгдүгээр хавсралт


Техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:

- Техникийн хэлтсийн дарга;

Комиссын гишүүд:

- Ерөнхий инженер;
- Техникийн хэлтсийн мэргэжилтэн;
- Хэмжилт, засварын төвийн дарга;
- Хэмжилт, засварын төвийн ахлах инженер;
- Телевизийн төв станцын дарга;
- Телевизийн төв станцын ахлах инженер;
- Радио нэвтрүүлэх төв станцын дарга;
- Радио нэвтрүүлэх төв станцын ахлах инженер;
- Хотын шугамын радиогийн албаны дарга;
- Хотын шугамын радиогийн албаны ахлах инженер;
- Баян-Өлгийн аймгийн Радио телевизийн сүлжээний газрын дарга;
- Баян-Өлгий аймгийн Радио телевизийн сүлжээний газрын ахлах инженер;
- Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын дарга;
- Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын ахлах инженер;
- Дорнод аймгийн Радио телевизийн сүлжээний газрын дарга;
- Дорнод аймгийн Радио телевизийн сүлжээний газрын ахлах инженер;
- Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын дарга;
- Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын ахлах инженер;
- Өмнөговь аймгийн Радио телевизийн сүлжээний газрын дарга;
- Өмнөговь аймгийн Радио телевизийн сүлжээний газрын ахлах инженер.



Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2021 оны 117 тушаалын хоёрдугаар хавсралт

СҮЛЖЭЭНИЙ ДЭД БҮТЭЦ АШИГЛАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Иргэн, хуулийн этгээдийн /цаашид ЗАХИАЛАГЧ гэх/ техник, тоног төхөөрөмжийг радио телевизийн газрын дахин дамжуулах сүлжээ /цаашид СҮЛЖЭЭ гэх/- ний дэд бүтцэд холбох, суурилуулах, эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгоход энэхүү журмын зорилго оршино.

1.2.Захиалагчийн сүлжээний дэд бүтцийг ашиглах хүсэлтийн дагуу тодруулга, судалгааг хийх, холболт, суурилуулалт, ашиглалтын үеийн үндсэн шаардлагуудыг тусгасан техникийн нөхцөл олгох, инженерийн байгууламжийн өргөтгөл, засвар, шинээр баригдаж буй барилга байгууламжууд тус газрын эзэмшлийн сүлжээний хамгаалалтын зурваст орж байгаа эсэх, агаарын шугамын байгууламжтай огтлолцох, давхцах, хаалттай бүс үүсгэж байгаа талаарх тодруулга олгох үйл ажиллагааг тус тус энэхүү журмаар зохицуулна.

1.3.Байгууллагын харьяа газар, станц, алба, засварын төв нэгж /Телевизийн төв станц, Радио нэвтрүүлэх төв станц, Хотын шугамын радиогийн алба, Хэмжилт засварын төв, Орон нутгийн Радио телевизийн сүлжээний газрууд, бусад/ тус бүрийг цаашид САЛБАР НЭГЖ гэх;

Хоёр. Техникийн нөхцөл олгох үндэслэл

2.1.Захиалагчийн техникийн нөхцөл авах хүсэлтийг Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь албан бичгээр хүлээн авна. Захиалагч нь зөвхөн нэмэлт мэдээллийг и-мэйлээр ирүүлнэ.

2.2.Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь захиалагчийн урьд хийгдсэн гэрээний биелэлт, төлбөр тооцоо, төлбөрийн чадвар, байгууллагын бодлогод хэрхэн нийцэж байгаа зэргийг судалж нөхцөл олгох боломжтой бол хүсэлтийн хуулбар дээр түрээслэх боломжтой гэсэн цохолт хийж Захиалагчаас хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 2 хоногт багтаан Техникийн хэлтэст ирүүлнэ.

2.3.Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийг дараах мэдээллийн хамт ирүүлнэ.

2.3.1.Иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг, утас

2.3.2.Техникийн нөхцөл авах болсон шалтгаан

2.3.3.Төхөөрөмжийн марк, тоо ширхэг, хэмжээ

2.3.4.Төхөөрөмжийн хүчин чадал, эрчим хүчний хэрэглээ

2.4.Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь захиалагчийн урьд хийгдсэн гэрээний биелэлт, төлбөр тооцоо, төлбөрийн чадвар, байгууллагын бодлогод хэрхэн нийцэж байгаа зэргийг судалж нөхцөл олгох боломжгүй гэж үзсэн бол Захиалагчид боломжгүй тухай хариуг албан бичгээр хүргүүлнэ.

2.5.Техникийн хэлтэс нь шаардлагатай бол Захиалагчаас дараах мэдээллийг нэмэлтээр бүрдүүлж авсан байна.

2.5.1.Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хуулбар

/Харилцан нөлөөлөлд орох магадлалтай бол баталгаа гаргуулах, шаардлагатай бол Харилцаа холбооны зохицуулах хорооны тооцоолол/

2.5.2.Холболт хийх цэг

Гурав. Техникийн нөхцөл олголт

3.1.Техникийн нөхцөлийг сүлжээний дэд бүтцийн багтаамж, харилцан холболтын нөхцөл, эрчим хүчний хүчин чадалд үндэслэн техникийн нөхцөл олгох комисс олгоно.

3.2.Техникийн хэлтсийн мэргэжилтэн нь Маркетинг төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн бичиг баримтыг хянаж бүрэн гүйцэд, шаардлага хангасан тохиолдолд хүлээн авснаас хойш ажлын 2 хоногт багтаан холбогдох салбар нэгжийн ахлах инженерт хүсэлтийг "Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-ийн /erp.e-mongolia.mn/ үүрэг даалгавар цэсд оруулж шилжүүлнэ.

3.3.Холбогдох салбар нэгжийн ахлах инженер нь сүлжээний дэд бүтцийн багтаамж, агаарын шугамын трасс, харилцан холболтын нөхцөл, эрчим хүчний ачааллыг тооцон судалгааг хийж боломжтой тохиолдолд урьдчилсан техникийн нөхцөлийг боловсруулан салбар нэгжийн даргаар хянуулж ажлын 5 хоногт багтаан Техникийн хэлтэст ирүүлнэ. Техникийн нөхцөлд салбар нэгжийн дарга, ахлах инженер гарын үсэг зурж, тамга дарж албажуулсан байна.

3.4.Техникийн хэлтсийн мэргэжилтэн, ерөнхий инженер нь техникийн нөхцөлийг хянаж шаардлагатай бол тодруулга хийж стандарт нөхцөл шаардлагад нийцүүлэн дахин боловсруулан Техникийн хэлтсийн даргаар батлуулна.

3.5.Техникийн нөхцөл боловсруулах явцад зайлшгүй газар дээр нь судалгаа хийх шаардлагатай бол төлөвлөлтийн инженер техникийн ажилтан нар хамтран гүйцэтгэнэ.

3.6.Техникийн байр, цамхагт төхөөрөмжийг ямар нэг нэмэлт тооцоо, тодруулга шаардахгүйгээр суурилуулах, сүлжээний системд холбох, эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгоход Захиалагчаас хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 12 хоногт багтаан техникийн нөхцөлийг олгоно.

3.7.Дараах тохиолдолд Захиалагчаас хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 хоногт багтаан техникийн нөхцөлийг олгоно. Үүнд:

3.7.1.Тухайн хүсэлтийг биелүүлэхэд шаардлагатай тус газрын сүлжээний дэд бүтэц, эрчим хүч, техникийн болон бусад өргөтгөл, шинэчлэлийг хийх, нэмэлт төхөөрөмж шаардлагатай бол;

3.7.2.Зам гүүр, бусад инженерийн байгууламж, эрчим хүч, шилэн кабелийн шугам сүлжээ, харилцан нөлөөллийн талаарх тооцоолол болон бусад шаардлагатай мэдээллийг гадны байгууллагаас тодруулга авах бол;

3.8.Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацааг батлагдсанаас хойш хуанлийн 45 хоногоор тогтооно.

3.9.Захиалагч техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд ажлыг хийгээгүйгээс хугацаа дууссан тохиолдолд дахин хүсэлт гаргаж техникийн нөхцөлийг шинээр авна.

3.10.Захиалагч урьд нь олгосон техникийн нөхцөлийн шаардлагыг 2-с дээш удаа ноцтой зөрчсөн, ашиглалтын үйл ажиллагаанд муугаар нөлөөлсөн тохиолдолд техникийн нөхцөл олгохгүй байж болно.

3.11.Энэхүү журмын 3.10-р заалтыг Захиалагчтай хийх гэрээнд Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь заавал тусгаж оруулж өгсөн байна.

3.12.Техникийн нөхцөлийг 4 хувь үйлдэх ба Техникийн хэлтэст 1 хувь, Маркетинг төлөвлөлтийн хэлтэст 1 хувь, Салбар нэгжид 1 хувь, Захиалагчид 1 хувь тус тус хадгалагдана.

3.13.Техникийн хэлтэс нь Маркетинг төлөвлөлтийн хэлтэст батлагдсан техникийн нөхцөлийн 2 хувийг өгөх бөгөөд Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь Захиалагчид техникийн нөхцөлийн эх хувийг хүргүүлэх үүрэгтэй.

3.14.Батлагдсан техникийн нөхцөлийн 1 хувийг сүлжээний дэд бүтэц ашигласан ажлын гүйцэтгэлийг шалгах техникийн актын маягт /Хавсралт 1/-ын хамт салбар нэгжийн дарга, ахлах инженерт Техникийн хэлтсээс хүргүүлж танилцуулна.

3.15.Техникийн нөхцөлийн дагуу Захиалагчийн ажлыг гүйцэтгүүлэх үүргийг тухайн салбар нэгж бүрэн хариуцах бөгөөд ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажлыг хүлээж авна.

3.16.Салбар нэгжийн дарга нь хяналт тавих инженер техникийн ажилтныг томилно.

3.17.Томилогдсон инженер техникийн ажилтан нь биеэр байлцан ажлыг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллах ба техникийн нөхцөлийг хэрхэн хангасан тухай үнэн зөвөөр тайлагнана.

3.18.Томилогдсон инженер техникийн ажилтан нь сүлжээний дэд бүтэц ашигласан ажлын гүйцэтгэлийг шалгасан техникийн актыг бүрэн гүйцэд, үнэн зөв үйлдэж, салбар нэгжийн даргаар хянуулж, гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох гүйцэтгэлийн зургийн хамт ажил гүйцэтгэснээс хойш ажлын 5 хоногт багтаж Техникийн хэлтэст ирүүлнэ. Техникийн актыг 4 хувь үйлдэж ирүүлнэ.

3.19.Техникийн актад ажил гүйцэтгэж дууссан огноог тодорхой тусгасан байх ба актыг гүйцэтгэгчээр баталгаажуулсан байна.

3.20.Техникийн хэлтэс нь техникийн актыг Захиалагчаар баталгаажуулж, Маркетинг төлөвлөлтийн хэлтэст 1 хувь, Захиалагчид 1 хувь, Салбар нэгжид 1 хувийг тус тус өгөх ба Техникийн хэлтэст 1 хувь хадгалагдана.

3.21.Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь техникийн актыг үндэслэн гэрээг байгуулах ба техникийн актанд тусгасан ажил гүйцэтгэж дууссан өдрөөс гэрээний эхлэх хугацааг тооцно.

3.22.Маркетинг төлөвлөлтийн хэлтсээс гэрээний хуулбарыг тухайн салбар нэгжийн удирдлагад хүргүүлнэ.

3.23.Салбар нэгжүүд нь байр талбай, эрчим хүчний ачаалал, цамхгийн даац, багтаамж норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд техникийн нөхцөл олгох боломжгүй үндэслэлээ техникийн тооцоо, зураг зэрэг баримтыг хавсарган дотоод албан бичгээр ажлын 5 хоногт багтаан Техникийн хэлтэст ирүүлнэ.

3.24.Техникийн хэлтсээс техникийн нөхцөл олгох боломжгүй тухай дүгнэлт гарсан бол энэ тухай дотоод албан бичгийг техникийн нөхцөл олгох боломжгүй тухай тооцоо, баримт бичгийн хамт Маркетинг төлөвлөлтийн хэлтэст өгнө.

3.25.Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь Техникийн хэлтсээс ирүүлсэн албан бичгийг үндэслэн Захиалагчид хариуг хүргүүлэх үүрэг хүлээнэ.

3.26.Зам гүүр, бусад инженерийн байгууламжийн шугам сүлжээний өргөтгөл, засвар, шинээр баригдаж буй барилга байгууламжууд манай эзэмшлийн сүлжээний

хамгаалалтын зурваст орж байгаа эсэх, агаарын шугамын байгууламжтай огтлолцох, давхцах, хаалттай бүс үүсгэж байгаа талаарх тодруулга авах хүсэлтийг хүлээн авсан салбар нэгж нь ажлын 5 хоногт багтаан шалгаж, хариуг дотоод албан бичгээр Техникийн хэлтэст ирүүлнэ.

Дөрөв. Техникийн нөхцөлийн агуулга

- 4.1. Техникийн нөхцөлд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:
 - 4.1.1. Дэд бүтцийн байршил
 - 4.1.2. Техник, тоног төхөөрөмжийн тоо, хэмжээ, чадал
 - 4.1.3. Суурилуулалтын байршил /зураг, холболтын схем/
 - 4.1.4. Харилцан холболтын цэг
 - 4.1.5. Эрчим хүчний холболт
 - 4.1.6. Газардуулга
 - 4.1.7. Харилцан нөлөөлөл
 - 4.1.8. Угсралт, ашиглалт, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлага
 - 4.1.9. Хаягжилт
 - 4.1.10. Онцгой нөхцөл, шаардлага
 - 4.1.11. Холбогдох хууль, дүрэм, стандарт, тогтоол
 - 4.1.12. Техникийн акт
 - 4.1.13. Ажилд өгөх
 - 4.1.14. Техникийн нөхцөлийн хугацаа

Тав. Нөхцөл шаардлага

5.1. Техникийн нөхцөлгүйгээр сүлжээний дэд бүтцийг ашиглуулах, гэрээ хийхийг хориглоно.

5.2. Энэхүү журмын 3.23-д заасан нөхцөл бүрдсэн үед техникийн нөхцөл олгохгүй бөгөөд тухайн хариуцсан салбар нэгжээс цаашид өргөтгөл шинэчлэл хийх үндэслэл тооцоо, саналыг гаргаж хэрэгжүүлнэ.

Зургаа. Бусад

- 6.1. Техникийн нөхцөлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно.
 - Захиалагчаас техникийн өгөгдлөө буруу тодорхойлсон
 - Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд ажил хийгдээгүй
- 6.2. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.
- 6.3. Энэхүү журмыг баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.
- 6.4. Захиалагчийн буруутай үйлдлээс шалтгаалан техникийн нөхцөл хангаагүй техникийн акт ирүүлсэн тохиолдолд актыг үндэслэн Маркетинг төлөвлөлтийн хэлтэс нь гэрээг байгуулахаас татгалзаж болно.
- 6.5. Салбар нэгжүүд нь суурилуулалтын явцад зөрчил илрэх үед мэдэгдэж зөрчлийг арилгуулах, тэжээлээр хангах, суурилуулалтыг зогсоох эрхтэй байх;
- 6.6. Захиалагчийн буруутай үйлдлээс шалтгаалан техникийн нөхцөл хангаагүй техникийн акт ирүүлсэн тохиолдолд актыг үндэслэн Техникийн хэлтэс нь техникийн нөхцөлийг хангуулах, шаардлагатай бол Захиалагчийн суурилуулсан техник, тоног төхөөрөмжийг буулгах тухай Захиалагчид албан бичгээр, мөн тухайн салбар нэгжид

дотоод албан бичгээр мэдэгдэх ба Техникийн хэлтэс нь тоног төхөөрөмжөө буулгахыг Захиалагчаас шаардана.

Долоо. Хариуцлага


7.1.Энэхүү журмыг зөрчсөн маргаантай асуудлыг талууд шат шатандаа шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадахгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.2.Захиалагч техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд тухайн ажил үйлчилгээг хийгээгүйгээс гарах үр дагаврыг аль нэг хэлтэс, салбар нэгж хариуцахгүй.

7.3.Техникийн нөхцөл буруу гаргаснаас гарах үр дагавар, хариуцлагыг боловсруулсан, хянасан, баталсан этгээд хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

7.4.Ажлын гүйцэтгэлд харьяалах инженер техникийн ажилтныг байлцуулж хяналт хийгээгүй, мөн хяналт хийсэн инженер техникийн ажилтнуудын хариуцлагагүйгээс техникийн нөхцөл хангаагүй тохиолдолд гарах үр дагавар, хариуцлагыг тухайн салбар нэгжийн удирдлага, инженер техникийн ажилтнууд хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

--оОо--



"Радио телевизийн үндэсний сүлжээ" улсын
төсөвт үйлдвэрийн газрын захирлын
2021 оны 11-р сарын 17-ны өдөр тушаалын гуравдугаар хавсралт

СҮЛЖЭЭНИЙ ДЭД БҮТЭЦ АШИГЛАСАН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ШАЛГАСАН ТЕХНИКИЙН АКТ

№

1	Захиалагч аж ахуй нэгж	
2	Техникийн нөхцөл	Дугаар: Огноо:
3	Ажил гүйцэтгэсэн	Аж ахуй нэгж:
		Ажилтан:
		Албан тушаал:
		Утасны дугаар:
4	Ажил гүйцэтгэсэн хугацаа	Эхэлсэн огноо:
		Дууссан огноо:

5. Ажлын гүйцэтгэл техникийн нөхцөлийг хангасан эсэх талаар:

5.1.Төхөөрөмжийн суурилуулалт /ТН-д заасан байршил, хэмжээ, тоо ширхэгээр технологийн дагуу суурилуулсан эсэх, тухайн төхөөрөмж болон бусад төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх боломжтой эсэх/:

.....
.....
.....
.....
.....

5.2.Газардуулга:

.....
.....
.....

5.3.Фидер /бэхэлгээ, дамнуурга, оруулга/:

.....
.....
.....

5.4.Металл хийцэд өөрчлөлт оруулахгүй байх /агнах, нүхлэх, тасдахыг хориглоно/:

.....
.....
.....

5.5.Холболтын кабелиуд /кабелийн тавиураар татсан эсэх, ил хэсгийн кабель далдлагч/:

.....
.....
.....

5.6.Эрчим хүчний холболт, тоолуур /ТН-д заасан цахилгаан эрчим хүчээр хангах бүх нөхцөлийг хангасан эсэх/:

.....
.....
.....

.....
5.7.Харилцан нөлөөлөл:
.....
.....

5.8.Хаягжилт:
.....
.....

5.9.Ажлын гүйцэтгэлийн зураг /Зургийн тоо ширхэг/
.....
.....

5.10.Ажлын гүйцэтгэлд хяналт тавихаар томилогдсон инженер техникийн ажилтан байлцсан эсэх:
.....
.....

5.11.Бусад:
.....
.....
.....

6. Суурилуулалтын явцад техникийн нөхцөлийг өөрчилсөн тохиолдол гарсан бол шалтгаан:
.....
.....
.....

7. Дүгнэлт:
.....

8. Актыг 4 хувь үйлдэж захиалагч тал 1 хувь, түрээслэгч тал 3 хувийг тус тус авна.

Захиалагч талаас:
.....

Гүйцэтгэгч талаас:
.....

Түрээслэгч талаас:

Хянасан:

Салбар нэгжийн дарга

..... /

Шалгаж хүлээн авсан:

Ахлах инженер

..... /

Ашиглалт хариуцсан инженер

..... /

Антен фидер хариуцсан инженер

..... /

Албан тушаалтны нэр :

Албан тушаалтны нэр :

Гарын үсэг:

Гарын үсэг:

Утас:

Утас: